



Сүхбаатар аймаг дахь Төрийн аудитын газар

САНХҮҮГИЙН АУДИТЫН НЭГТГЭСЭН ТАЙЛАН

СҮХБААТАР АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН 2023 ОНЫ НЭГДСЭН
ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛИЙН ТАЙЛАНД ХИЙСЭН САНХҮҮГИЙН
ТАЙЛАНГИЙН АУДИТЫН ХУРААНГУЙ ТАЙЛАН

Баруун-Урт сум 2024 он



Дарга, тэргүүлэх аудитор Г.Даваа

Утас: 70518396 Цахим хаяг: Davaag@audit.gov.mn

Аудитын менежер М.Нарантуяа

Утас: 70512123 Цахим хаяг: Narantuyam@audit.gov.mn

Ахлах аудитор О.Барчидгүнсэн

Утас: 70512127 Цахим хаяг: barchidgunseno@audit.gov.mn

Аудитор Ө.Золзаяа

Утас: 70512127 Цахим хаяг: zolzayau@audit.gov.mn

Агуулга

БҮЛЭГ 1. Орон нутгийн төсвийн орлогыг 84,944.7 сая төгрөгөөр төлөвлөж, гүйцэтгэлээр 68,326.9 сая төгрөг төвлөрчээ.	2
Бүлэг 2. Зарим нэр төрлийн зарлагыг шинээр нэмж баталсан нь төсвийн тухай хуультай нийцээгүй байна.	4
БҮЛЭГ 3. Тайлант онд нийт 459 төсөл арга хэмжээг хэрэгжүүлэхээр төлөвлөж 40,570.1 сая төгрөгөөр санхүүжүүлэхээр баталсан ба гүйцэтгэл 54.6 хувьтай байна.	6
БҮЛЭГ 4. Орон нутгийн 2023 оны хөгжлийн төлөвлөгөөнд тусгагдсан арга хэмжээний хүрэх түвшин, шалгуур үзүүлэлтийг төсвийн төсөлтэй уялдуулан үндэслэлтэй төлөвлөөгүйгээс зарим арга хэмжээ хэрэгжээгүй байна.	7
БҮЛЭГ 5. Нэмэлт төсвийн эх үүсвэрийг хууль тогтоомжийн дагуу бүрдүүлэн, зарцуулжээ.	8
БҮЛЭГ 6. Санхүү, төсвийн үйл ажиллагаатай холбоотой ил тод мэдээлбэл зохих мэдээллийг ШДНЦХ-т байршуулаагүй, хугацаа хоцроож мэдээлсэн байна.	8
ДҮГНЭЛТ.	9
ЗӨВЛӨМЖ:	9
САНАЛ:	10

БҮЛЭГ 1. Орон нутгийн төсвийн орлогыг 84,944.7 сая төгрөгөөр төлөвлөж, гүйцэтгэлээр 68,326.9 сая төгрөг төвлөрчээ.

1.1 Аймгийн ИТХ-аар орон нутгийн төсөвт тодотгол хийх нөхцөл үүсээгүй байхад урьд оны үлдэгдлээс санхүүжүүлэх эх үүсвэрийг 3,876.5 сая төгрөгөөр нэмэгдүүлэн баталжээ.

1.1.1 Аймгийн ИТХ-ын 2022 оны 12 дугаар сарын 02-ны өдрийн 07 тоот тогтоол болон сумдын ИТХ-ын тогтоолоор орон нутгийн төсвийн татварын орлогыг 35,900.4 сая, татварын бус орлогыг 5,299.5 сая, үндсэн болон туслах үйл ажиллагааны орлогыг 3,838.5 сая, тусламж, санхүүгийн дэмжлэг 21,995.2 сая, урьд оны үлдэгдлээс 5,517.3 сая нийт орон нутгийн төсвийн орлого, зарлагыг санхүүжүүлэх эх үүсвэрийг 72,550.9 сая төгрөгөөр төлөвлөж баталсан байна.

1.1.2 Монгол Улсын 2023 оны Төсвийн тухай хуулиар Сүхбаатар аймагт олгох санхүүгийн дэмжлэгийг 8,293.2 сая, орон нутгийн хөгжлийн санд олгох орлогын шилжүүлгийг 13,702.0 сая төгрөгөөр тус тус баталсан байна.

1.1.3 Монгол Улсын 2023 оны Төсвийн тухай хуульд 2023 оны 06 дугаар сарын 16-ны өдөр нэмэлт, өөрчлөлт орж, орон нутгийн төсөвт олгох санхүүгийн дэмжлэгийг 1,476.2 сая, орон нутгийн хөгжлийн санд олгох орлогын шилжүүлгийг 3,451.7 сая төгрөгөөр тус тус нэмэгдүүлэн баталжээ.

1.1.4 Сүхбаатар аймгийн 2023 оны төсвийг Төсвийн тухай хууль, "Орон нутгийн төсвийн төсөл боловсруулах" журам, аймгийн 2023 оны төсвийн хүрээний мэдэгдэл, өмнөх оны гүйцэтгэлд үндэслэн төлөвлөж, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.5.1, 8.5.2-т заасан цаглабарын дагуу тухайн шатны ИТХ-д өргөн мэдүүлжээ.

1.1.4 Монгол Улсын 2023 оны төсвийн тухай хууль орсон нэмэлт өөрчлөлтийн хүрээнд аймаг, сумдын ИТХ-ын "Төсвийн тодотгол батлах тухай" тогтоолд орон нутгийн төсвийн зарлагыг

санхүүжүүлэх эх үүсвэрийг 12,418.4 сая төгрөгөөр нэмэгдүүлэн 84,944.7 сая төгрөгөөр баталжээ.

1.1.5 Орон нутгийн төсөвт аймаг 3 удаа, сумд 1 удаагийн нэмэлт өөрчлөлт оруулж тодотгол хийжээ.

1.1.6 Аймгийн ИТХ-аас 2022 оны 12 дугаар сарын 30-ны өдөр болон 2023 оны 03 дугаар сарын 31-ны өдөр төсөвт 2 удаагийн тодотгол хийгдсэн байна. Тодотгол хийсэн нөхцөл байдлыг авч үзвэл:

• **Аймгийн 2022.12.30, 2023.03.31-ний өдрийн ИТХ-аар:**

Тодотголоор аймгийн 2023 оны төсвийн зарлагын санхүүжүүлэх эх үүсвэрийг 3,674.9 сая төгрөг (орон нутгийн ерөнхий орлогын дансны үлдэгдлээс 3,482.4 сая, барилга техник хяналтын дансны үлдэгдлээс 192.5 сая)-өөр нэмэгдүүлэн аймгийн нийт орлогыг 52,285.1 сая төгрөгөөр баталжээ. Төсвийн тухай хуулийн 34 дүгээр зүйлийн 34.2-т заасны дагуу орон нутгийн төсөвт тодотгол хийх нөхцөл байдлыг бодитой тодорхойлоогүй байна.

1.1.7 Аймгийн ИТХ-аас 2024 оны 07 дугаар сарын 26-ны өдөр тодотгол хийсэн байна. Тодотгол хийсэн нөхцөл байдлыг авч үзвэл:

• **Аймгийн 2024.07.26-ны өдрийн ИТХ-аар:**

Монгол Улсын 2023 оны Төсвийн тухай хуульд нэмэлт өөрчлөлт орсонтой холбоотой орон нутгийн төсөвт тодотгол хийгджээ. Төрийн албан хаагчдын цалин хөлс нэмэгдэж, дээд шатны төсөвт тодотгол хийгдсэнээс орон нутгийн төсөвт нэмэлт өөрчлөлт орсон бөгөөд уг тодотголоор санхүүгийн дэмжлэгийг 1,476.2 сая, ОНХНС-аас хуваарилагдан ирэх орлогын шилжүүлгийг 3,451.7 сая төгрөгөөр тус тус нэмэгдүүлжээ. Мөн авто тээвэр болон өөрөө явагч хэрэгслийн албан татварын төлөвлөгөөг 150.0 сая төгрөгөөр, урьд оны үлдэгдлээс 201.6 сая төгрөгөөр (барилга техник хяналт 3.7 сая, авто замын сан 190.4 сая, ОНХС 7.5) төсвийн зарлагын эх үүсвэрийг санхүүжүүлэхээр тус тус тодотгосон байна.

1.1.8 Төсвийн тухай хуульд заасан нөхцөл байдал үүссэн эсэхэд дүн шинжилгээ хийгээгүй орон нутгийн төсөвт тодотгол хийгдэж байгаа нь Төсвийн төслийг бодитой, хариуцлагатай төлөвлөгөөгүйтэй холбоотой байна.

1.2 Орон нутгийн төсвийн орлогод газрын дуудлага худалдаагаар 6,118.5 төгрөгийн орлого төвлөрөхөөр төлөвлөсөн боловч 5,201.0 сая төгрөгөөр тасарчээ.

1.2.1 Сүхбаатар аймгийн ИТХ-ын 2023 оны 07 дугаар сарын 26-ны өдрийн 01 тоот тогтоол болон сумдын ИТХ-ын “Төсвийн тодотгол батлах тухай” тогтоолд 2023 оны төсвийн нийт орлого, тусламжийн дүнг 84,944.7 сая төгрөгөөр төлөвлөснөөс 68,326.9 сая төгрөгийн гүйцэтгэлтэй байна.

1.2.2 Тайлант оны татварын орлогын гүйцэтгэл 32,729.8 сая төгрөг буюу төлөвлөснөөс 5,434.9 сая төгрөгөөр тасарсан байна.

1.2.3 Татварын орлогын гүйцэтгэл нийт дүнгээр 86 хувийн гүйцэтгэлтэй байгаа боловч дараах нэр төрлийн орлого 15-71 хувийн гүйцэтгэлтэй байна. Үүнд:

- Газрын дуудлага худалдааны орлого 5,201.8 сая төгрөг буюу 15 хувь, шууд бус орлого 88.4 сая төгрөг буюу 26 хувь, түгээмэл тархацтай ашигт малтмал ашигласны төлбөр 20.0 сая төгрөг буюу 38 хувь, малд ногдуулах албан татвар 1,272.7 сая төгрөг буюу 38 хувь, байгалийн ургамлын нөөц ашигласны төлбөр 130.0 сая төгрөг буюу 46 хувь, хог хаягдлын үйлчилгээний хураамж 100.6 сая төгрөг буюу 63 хувь, ан амьтны нөөц ашигласны төлбөр 186.9 сая төгрөг буюу 71 хувиар тус тус тасарсан байна.

1.2.4 Татварын орлого тасрахад байгаль, цаг уурын давагдашгүй хүчин зүйл тохиолдож, малын тоо толгой их хэмжээгээр хорогдсон, хадгаламжийн хүү буурсан, иргэдийн орлогод хялбаршуулсан горимоор татвар ногдуулсан, газар зохион байгуулалтын төлөвлөгөөнд тусгагдсан газрын дуудлага худалдааны орлогыг зохион байгуулагдаагүй нь гол нөлөөлөл үзүүлжээ.

1.2.5 Аймгийн 2023 оны татварын орлого нийт дүнгээр 24 хувиар тасарсан боловч зарим орлого төлөвлөснөөс 3,158.1 сая төгрөгөөр давж биелсэн байна. *Тухайлбал:*

- Улсын тэмдэгтийн хураамж, газрын төлбөр, авто тээврийн болон өөрөө явагч хэрэгслийн татвар, үл хөдлөх хөрөнгийн татварын биелэлт 106-112 хувь, цалин хөлс түүнтэй адилтгах орлогын татвар, хөрөнгө борлуулсны орлогын татвар, ус, рашааны нөөц ашигласны төлбөрийн орлого 131-165 хувиар давж биелсэн ба 58.5 сая төгрөгийн төлөвлөгдөөгүй орлого төвлөрсөн байна.

1.2.6 Татварын орлого давж биелэхэд хөрөнгө борлуулсны орлогын татвар, ус рашаан ашигласны төлбөр, улсын тэмдэгтийн хураамж зэргийг урьдчилан төлөвлөх боломжгүй тул өмнөх оны гүйцэтгэлд суурилан төлөвлөсөн, нэр төрлийн орлогыг

1.2.7 Татварын бус орлогыг 6,401.8 сая төгрөгөөр төлөвлөж, гүйцэтгэлээр 5,771.2 сая төгрөгийн орлого төвлөрч 90 хувийн биелэлттэй гарчээ.

1.2.8 Татварын бус орлого тасрахад дараах хүчин зүйл нөлөөлжээ. Үүнд

- Уул уурхайн ашиглалтын тусгай зөвшөөрөл эзэмшигч аж ахуйн нэгж байгууллагатай Ашигт малтмалын тухай хуулийн 42 дугаар зүйлийн 42.1-т заасны дагуу хамтран ажиллах гэрээ байгуулж, орон нутгийн төсөвт орлого төвлөрүүлэхээр тусгасан байдаг. Гэрээ байгуулсан тусгай зөвшөөрөл эзэмшигч аж ахуйн нэгж байгууллагууд хэвийн үйл ажиллагаа явуулаагүй гэх шалтгаанаар татварын бус орлогыг төсөвт төвлөрүүлээгүй байна.

1.2.9 Татварын болон татварын бус орлого тасарсан нь орон нутгийн орлогын төлөвлөлтөд дүн шинжилгээ хийж, бааз суурийг бодитой авч үзээгүй, хамтран ажиллах гэрээний үүргийн хэрэгжилтийг хангуулахад төрийн захиргааны холбогдох албан тушаалтнууд хариуцлагатай байх хандлага дутмаг байсан, орлогын нэр төрөл тус бүрийг төвлөрүүлэхэд төрийн захиргааны байгууллагын хамтын ажиллагаа үр дүн муутай байгаа зэргээс шалтгаалж байна.

Бүлэг 2. Зарим нэр төрлийн зарлагыг шинээр нэмж баталсан нь төсвийн тухай хуультай нийцээгүй байна.

2.1 Аймгийн ИТХ-ын 2023 оны 3 сарын 31-ний өдрийн 03 дугаар тогтоолоор төсвийн зарлагын хэмжээг 3,674.9 сая төгрөгөөр нэмэгдүүлэн баталжээ.

2.1.1 Сүхбаатар аймгийн ИТХ-ын 2022 оны 12 дугаар сарын 02 -ны өдрийн 07 тоот тогтоол болон сумдын ИТХ-ын “2023 оны төсөв батлах тухай” тогтоолд Төсвийн Ерөнхийлөн захирагчийн 2023 оны төсвийн нийт зарлагыг 72,526.3 сая төгрөгөөр баталсан байна.

2.1.2 Сүхбаатар аймгийн ИТХ-ын 2023 оны 07 дугаар сарын 26-ний өдрийн “2023 оны төсвийн тодотгол батлах тухай” 01 дүгээр тогтоол болон сумдын ИТХ-ын төсөвт өөрчлөлт оруулах тухай тогтоолоор 2023 оны төсвийн нийт зарлагыг 12,418.4 сая төгрөгөөр нэмэгдүүлэн 84,944.7 сая төгрөгөөр баталсан байна.

2.1.3 Төсвийн тухай хуулийн 34 дүгээр зүйлийн 34.2-т заасан төсөвт тодотгол хийх нөхцөл үүсээгүй байхад 800.0 сая төгрөгийн зардлыг шинээр нэмж баталсан байна. Үүнд:

- Хүмүүнлэгийн зарим үйл ажиллагааг Улаан загалмайн хороогоор гүйцэтгүүлэхэд 350.0 сая;
- Хүүхдийн хөгжил хамгааллыг дэмжих жилийн зардалд 50.0 сая;
- Хүүхдийн эрүүл мэндийн үзлэгт 100.0 сая;

○ Жижиг дунд үйлдвэрлэл эрхлэгчдэд олгох зээлд 300.0 сая төгрөг олгох зардлыг нэмж баталсан байна.

2.1.4 Мөн аймгийн ЗДТГ-ын зардал 320.0 сая, баяр наадмын зардал 35.0 сая, Засаг даргын мөрийн хөтөлбөр хэрэгжүүлэхтэй холбоотой зардал 350.0 сая, гамшгаас хамгаалах зардал 210.0 сая, төрийн зарим чиг үүргийг гэрээгээр гүйцэтгүүлэхтэй холбоотой гарах зардал 83.2 сая, барилга техник хяналтын зардал 192.5 сая, ХХОАТ-ын буцаан олголт 82.0 сая нийт 2,346.4 сая төгрөгийн урсгал зардлыг нэмэгдүүлэн баталжээ.

2.2 Орон нутгийн төсвийн зарлагын 53 хувийг урсгал зардал, 41 хувийг хөрөнгийн зардал, татаас, урсгал шилжүүлэг, эргэж төлөгдөх төлбөрийг хассан цэвэр зээл 5 хувийг эзэлж байна.

2.2.1 Сүхбаатар аймгийн 2023 оны төсвийн нийт зарлагын гүйцэтгэл 61,253.2 сая төгрөг буюу 72.1 хувийн гүйцэтгэлтэй байна.

2.2.2 Орон нутгийг төсвийн зарлага гүйцэтгэлээр бараа ажил үйлчилгээний зардал 39,872.7 сая, татаас 864.8 сая, урсгал шилжүүлэг 768.4 сая, хөрөнгийн зардал 18,631.5 сая, эргэж төлөгдөх зээл (ХХС, ЖДҮ) 1,112.1 сая нийт 61,253.2 сая төгрөг байна.

2.2.3 Орон нутгийн төсвийн зарлагын 53 хувийг урсгал зардал, 41 хувийг хөрөнгийн зардал, 5 хувийг татаас, урсгал шилжүүлэг, эргэж төлөгдөх төлбөрийг хассан цэвэр зээл байна.

2.2.4 “Тэрбум мод” үндэсний хөтөлбөрийн хүрээнд 159,680 ширхэг мод тарьж 637.2 сая төгрөгийг зарцуулжээ.

Аудитын илрүүлэлт:

Төсвийн гүйцэтгэлийн тайланг баталгаажуулах аудитаар дараах зөрчлүүд илэрсэн. Үүнд

- Аймгийн ИТХ-ын 06 дугаар тогтоол (нэмэгдэл олгохыг зөвшөөрөх тухай)-оор Улс төрийн, төрийн тусгай, төрийн үйлчилгээний албан хаагчид орон нутгийн нэмэгдлийг олгох шийдвэр гарч 614.7 сая төгрөгийн зарцуулалт гарсан байна. Энэ нь дээд шатны төсөв захирагчийн шийдвэр гараагүй байхад Төсвийн тухай хуулийн 31 дүгээр зүйлийн 31.1.3 дэх заалтыг зөрчин төсөв баталж, зарцуулалт хийгдсэн байна.
- Монголын Улаан загалмайн нийгэмлэгийн эрх зүйн байдлын тухай хуульд орон нутгаас тус нийгэмлэгийн үйл ажиллагаанд дэмжлэг үзүүлэхтэй холбоотой төсвийг баталж гэрээ байгуулахаар тусгасан байна. Гэтэл Засаг даргын 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөрийг хэрэгжүүлэхтэй холбоотой 350.0 сая төгрөгийг тодотголоор батлан, 250.0 сая төгрөгийн санхүүжилтийг хүмүүнлэгийн үйл ажиллагаанд зарцуулахаар олгосон байна. Энэ нь орон нутгийн чиг үүрэгт хамаарахгүй хөтөлбөр арга хэмжээ бөгөөд хүмүүнлэгийн тусламж нэрээр иргэдэд бэлэг тараасан үйлчилгээ болсон байна. Энэ нь Монгол Улсын засаг захиргааны нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 20, 21 дүгээр зүйлд заасан чиг үүрэгт нийцээгүй, 6.4.2 (төрийн болон орон нутгийн чиг үүрэгт хамаарахгүй хөтөлбөр, арга хэмжээг санхүүжүүлэхгүй байх;), 14 дүгээр зүйлийн 14.2.3 (өөрийн эрхлэх асуудлын хүрээнд төсвийг үр ашигтай удирдах, гүйцэтгэлийг хангах;), 14.3 (Төсвийн ерөнхийлөн захирагч өөрийн эрхлэх асуудлын төсвийн орлого, зарлагын зүй зохистой, үр ашигтай байдал, үр дүнгийн гүйцэтгэлийг хангаж, өөрт хамаарах төсвийн гүйцэтгэлийн биелэлтийг санхүү, төсвийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага, тухайн шатны иргэдийн Төлөөлөгчдийн Хурал, Засгийн газар, Улсын Их Хурлын өмнө бүрэн хариуцна.), 41 дүгээр зүйлийн 41.2.3 (төсвийн гүйцэтгэлийг хууль тогтоомжийн дагуу хэрэгжүүлж, тайлагнах;), Төрийн хэмнэлтийн тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1.5 (төсвийн болон байгууллагын хөрөнгөөр бэлэг дурсгалын зүйл худалдан авах;) заалтыг зөрчсөн байна.

- Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.2-д “... өөрт олгогдсон эд хөрөнгийн үндсэн дээр өөрийгөө санхүүжүүлэх зарчмаар ажиллаж бие даан иргэний гүйлгээнд ордог хуулийн этгээдийг аж ахуйн тооцоот үйлдвэрийн газар гэнэ” заасан байна. Гэтэл орон нутгийн өмчит аж ахуйн тооцоотой үйлдвэрийн зарим газрууд олсон орлогоороо өөрийгөө санхүүжүүлж чадахгүй, төсвөөс санхүүгийн дэмжлэг авч, төсвийн гүйцэтгэлд зарлага бий болгосон байна. Тухайлбал: “Бичигт их өргөө” 43.0 сая, “Сүхбаатар хөгжил, үйлдвэр технологийн парк” 50.0 сая, “Бичигт хөгжил” 20.0 сая, “Соёл амралтын хүрээлэн” 68.0 сая, “Түмэнцогт” 20.0 сая нийт 201.0 сая төгрөгийн санхүүгийн дэмжлэг олгосон нь Төсвийн тухай хуулийн 41 дүгээр зүйлийн 41.2.3 дахь заалттай нийцэхгүй байна. Иймд ОНӨААТҮГ-уудын үйл ажиллагааны чиглэл, ашигт ажиллагааны түвшнийг шалгуур үзүүлэлтийн дагуу үнэлж дүгнэн, орон нутгийн санхүүгийн дэмжлэгээс бусад орлогын эх үүсвэргүй, өөрийгөө санхүүжүүлэн бие даан үйл ажиллагаа явуулах чадамжгүй газруудад дүн шинжилгээ хийж, хуулийн дагуу арга хэмжээ авах шаардлагатай байна.
- “Шинэ суурьшлын бүс байгуулах” 3,600.0 сая төгрөгийн төсөвт өртөгтэй ТАХ-ний барилгын ажлыг газрын зөвшөөрөлгүй, магадлалаар баталгаажаагүй зураг төсвөөр эхлүүлсэн байна. Энэ нь Төрийн хэмнэлтийн тухай хуулийн 13 зүйлийн 3 дахь, 13 зүйлийн 3.3 дахь, Барилгын тухай хуулийн 25 зүйлийн 4 дэх заалтуудыг тус тус зөрчсөн байна.

БҮЛЭГ 3. Тайлант онд нийт 459 төсөл арга хэмжээг хэрэгжүүлэхээр төлөвлөж 40,570.1 сая төгрөгөөр санхүүжүүлэхээр баталсан ба гүйцэтгэл 54.6 хувьтай байна.

3.1 Тайлант онд ОНХС-ийн хөрөнгөөр хэрэгжих 413 төсөл арга хэмжээг 33,021.8 сая төгрөгөөр санхүүжүүлэхээр төлөвлөснөөс гүйцэтгэл 17,245.3 сая төгрөг буюу 52 хувьтай байна.

3.1.1 Сүхбаатар аймгийн ОНХС-ийн хөрөнгөөр нийт 58,660.0 сая төгрөгийн төсөвт өртөг бүхий 413 төсөл арга хэмжээг 33,021.8 сая төгрөгөөр санхүүжүүлэхээр аймаг, сумдын ИТХ-аар баталжээ.

3.1.2 Аймгийн ОНХС-ийн хөрөнгөөр өмнөх оноос шилжиж ирсэн 45 төсөл, арга хэмжээг 5,896.3 сая, шинээр хэрэгжиж буй 30 төсөл арга хэмжээг 11,517.8 сая, нийт 75 төсөл арга хэмжээг 17,414.1 сая төгрөгөөр санхүүжүүлэхээр төлөвлөснөөс 8,781.2 сая төгрөг буюу 50 хувийн гүйцэтгэлтэй байна.

3.1.3 Тухайн жилд хэрэгжих 24 төсөл арга хэмжээний 4,767.5 сая төгрөгийн санхүүжилтийг олгоогүй байна. Эдгээр төсөл арга хэмжээ нь холбогдох барим бичиг дутуу байснаас худалдан авах ажиллагааг зохион байгуулаагүй, тендер зарласан боловч амжилтгүй болсон, бүрэн хэрэгжээгүй, техникийн тодорхойлолтод заасан шалгуур, нөхцөлд нийцээгүй, гэрээг дүгнэж, улсын комисс хүлээж аваагүйтэй холбоотой байна.

3.1.4 Сумдын ИТХ-аар ОНХС-ийн хөрөнгөөр нийт 338 төсөл арга хэмжээнд 15,607.0 сая төгрөг зарцуулахаар баталсан байна.

3.1.5 Сумдын хэмжээнд санхүүжилтийн гүйцэтгэл 54 хувийн гүйцэтгэлтэй байгаа нь малын орлогын татварын гүйцэтгэл 38 хувь буюу бүрэн төвлөрөөгүйгээс санхүүжүүлэх эх үүсвэргүй болсон, тендер зарлаагүй, тухайн арга хэмжээг хэрэгжүүлэх нөхцөл үүсээгүй гэх мэт хүчин зүйлүүд нөлөөлсөн байна.

3.2 Их засварын хөрөнгөөр 13 төсөл арга хэмжээг 883.5 сая төгрөгөөр санхүүжүүлж, гүйцэтгэл 83.8 хувьтай байна.

3.2.1 Тайлант онд их засварын зардлаар хэрэгжүүлэх хөрөнгө оруулалтад 13 төсөл арга хэмжээнд 1,054.0 сая төгрөг баталж, гүйцэтгэлээр 9 төсөл арга хэмжээнд 883.5 сая төгрөгийн санхүүжилт олгож, гүйцэтгэл 83.8 хувьтай байна.

3.2.2 Аймгийн их засварын хөрөнгөөр өмнөх оноос шилжиж ирсэн 7 төсөл арга хэмжээг 237.0 сая, шинээр хэрэгжиж буй 6 төсөл арга хэмжээг 1,054.0 сая төгрөгөөр санхүүжүүлэхээр төлөвлөсөн байна.

3.2.3 Их засварын хөрөнгөөр 13 төсөл арга хэмжээг 883.5 сая төгрөгөөр санхүүжүүлж, гүйцэтгэл 83.8 хувьтай бөгөөд 12 төсөл арга хэмжээ бүрэн хэрэгжиж, 1 арга хэмжээний ажлын гүйцэтгэл 92 хувь байна.

3.3 Удирдлагыг хэрэгжүүлэх зардал 65.2 хувийн гүйцэтгэлтэй байгаа бөгөөд 2 төсөл арга хэмжээний санхүүжилтийг олгоогүй байна.

3.3.1 Удирдлага болон бусад чиг үүргийг хэрэгжүүлэх үйл ажиллагааны хөрөнгөөр шилжиж ирсэн 3, шинээр хэрэгжих 20, нийт 23 төсөл арга хэмжээг 5,387.4 сая төгрөгөөр гүйцэтгэхээр төлөвлөсөн байна.

3.3.2 Нийт 23 төсөл арга хэмжээний 18 арга хэмжээ 83-100 хувийн гүйцэтгэлтэй бөгөөд 5 арга хэмжээ хэрэгжээгүй нь орон нутгийн төсвийн орлого тасарснаас санхүүжилтийг эрэмбэлэн олгосонтой холбоотой байна.

3.4 Авто замын сангаар хэрэгжүүлсэн төсөл арга хэмжээ 46.1 хувийн гүйцэтгэлтэй байна.

3.4.1 Авто замын сангийн хөрөнгө оруулалтаар өмнөх оноос шилжиж ирсэн 6, шинээр хэрэгжүүлэх 4 нийт 2,532.0 сая төгрөгийн төсөвт өртөг бүхий 10 төсөл, арга хэмжээг 1,107.0 сая төгрөгөөр санхүүжүүлэхээр төлөвлөж баталсан.

3.4.2 Тайлант онд авто замын сангийн санхүүжилтийн гүйцэтгэл 509.9 сая төгрөг буюу 46.1 хувийн биелэлттэй байна.

3.4.3 Авто замын сангийн хөрөнгөөр орон нутгийн чанартай автозамын арчлалт, засвартай холбоотой ажлыг санхүүжүүлэхээр Автозамын сангийн тухай хуульд заасан байтал шинэ авто зам тавихад 627,2 сая төгрөгийг төлөвлөж, 129.2 сая төгрөг зарцуулсан нь тус хуулийн 24.8 дахь заалттай нийцэхгүй байна.

БҮЛЭГ 4. Орон нутгийн 2023 оны хөгжлийн төлөвлөгөөнд тусгагдсан арга хэмжээний хүрэх түвшин, шалгуур үзүүлэлтийг төсвийн төсөлтэй уялдуулан үндэслэлтэй төлөвлөөгүйгээс зарим арга хэмжээ хэрэгжээгүй байна.

4.1 Төсвийн гүйцэтгэлийн тайланг Төсвийн тухай хуульд заасан шалгуурт нийцүүлэн тайлагнасан байна

4.1.1 Сүхбаатар аймгийн Засаг даргын төсвийн гүйцэтгэлийн нэгдсэн тайлангаар 16 хөтөлбөр, арга хэмжээнд 61,253.3 сая төгрөгийг зарцуулж, гүйцэтгэл 72.1 хувьтай байна.

4.1.2 Төсвийг хөтөлбөр арга хэмжээ, хүрэх үр дүнгийн талаарх чанарын болон тоо хэмжээний үзүүлэлт, төсвийн захирагч бүрээр бэлтгэн батлуулж, гүйцэтгэлийг Төсвийн тухай хуульд нийцүүлэн тайлагнасан байна.

4.1.3 Төсвийн төвлөрүүлэн захирагч нарын хэрэгжүүлэх хөтөлбөр, хөтөлбөрийн үр дүнгийн талаарх чанарын болон тоон хэмжээний үзүүлэлтийн хэрэгжилтийг төсвийн гүйцэтгэлтэй уялдуулж, хяналт шинжилгээ, үнэлгээ хийж баталгаажуулаагүй байна.

4.1.4 Жижиг дунд үйлдвэрлэлээр хэрэгжүүлэх хөтөлбөрийн биелэлт 47.7 хувь буюу хангалтгүй байгаа нь тайлант онд Хоршоо хөгжүүлэх сангийн зээлийн нөхцөлд өөрчлөлт орсонтой холбоотой байна.

4.2 Аймгийн 2023 оны хөгжлийн төлөвлөгөөнд батлагдсан зарим арга хэмжээний санхүүжүүлэх эх үүсвэрийг төсвийн төсөлд бүрэн тусгаагүйгээс хэрэгжээгүй байна.

4.2.1 Сүхбаатар аймгийн 2023 оны хөгжлийн төлөвлөгөөг 2021-2025 онд хөгжүүлэх таван жилийн үндсэн чиглэл, Засаг даргын 2020-2024 оны үйл ажиллагааны төлөвлөгөөтэй уялдуулан 6 зорилт, 106 арга хэмжээг хэрэгжүүлэхээр батлуулж, гүйцэтгэл 88 хувьтай үнэлэгдсэн байна.

4.2.2 Сүхбаатар аймгийн 2023 оны хөгжлийн төлөвлөгөөнд тусгагдсан 106 арга хэмжээнд 37,727.6 сая төгрөгийг зарцуулсан байна.

4.2.3 Төлөвлөсөн арга хэмжээний 77 хувь буюу 82 арга хэмжээ 90-100 хувь, 16 арга хэмжээ 70 хувь, 8 арга хэмжээ 30-50 хувийн гүйцэтгэлтэй байна.

4.2.4 Хангалтгүй буюу 50 хүртэлх хувийн гүйцэтгэлтэй байгаа арга хэмжээг тайлант оны төсвийн тодотголоор хассан, санхүүжүүлэх эх үүсвэр тодорхойгүйгээс 2024 оны төсөвт шилжүүлэхээр төлөвлөсөн, тухайн арга хэмжээний зураг төсөв магадлалаар баталгаажуулах нь нөлөөлжээ.

4.2.4 Орон нутгийн 2023 оны хөгжлийн төлөвлөгөөнд тусгагдсан арга хэмжээний хүрэх түвшин, шалгуур үзүүлэлтийг бодитой тодорхойлоогүйгээс зарим арга хэмжээний биелэлтийг тооцох боломжгүй нөхцөл байдал үүссэн байна.

БҮЛЭГ 5. Нэмэлт төсвийн эх үүсвэрийг хууль тогтоомжийн дагуу бүрдүүлэн, зарцуулжээ.

5.1 Сүхбаатар аймгийн Засаг даргын 2023 оны нэмэлт төсөвт Засаг даргын нөөц хөрөнгөөс 716.4 сая, төрийн болон орон нутгийн өмчит бус этгээдээс авсан хандив тусламж 498.2 сая, дээд шатны төсвийн захирагчаас 967.4 сая, төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого 1,430.5 сая нийт 3,612.5 сая төгрөгийн орлого бүрдүүлжээ.

5.2 Нэмэлт төсвөөр бүрдүүлсэн эх үүсвэрийг эдийн засгийн ангиллаар дараах зардлуудад 3,143.4 сая төгрөг зарцуулж, үлдэгдэл 367.9 сая төгрөгийг төвлөрүүлсэн байна.

5.3 Нэмэлт төсвийн 87.0 хувийг бараа ажил үйлчилгээний зардалд, 13.0 хувийг урсгал шилжүүлэгт тус тус зарцуулсан байна.

БҮЛЭГ 6. Санхүү, төсвийн үйл ажиллагаатай холбоотой ил тод мэдээлбэл зохих мэдээллийг ШДНЦХ-т байршуулаагүй, хугацаа хоцроож мэдээлсэн байна

6.1 Төсөв захирагч нар Шилэн дансны тухай хууль, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор батлагдсан “Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам”-ыг хэрэгжүүлэх зорилгоор www.shilendans.gov.mn цахим хуудсанд мэдээллийг оруулсан байх үүрэгтэй.

6.2 Шилэн дансны нэгдсэн сайтад холбогдох мэдээллийг хуулийн хугацаанд байршуулаагүй, авлага, бонд, зээл, өрийн бичиг, баталгаа, түүнтэй адилтгах санхүүгийн бусад хэрэгсэл, төр, хувийн хэвшлийн түншлэлийн гэрээ, төсөв, өмч, хөрөнгө, мөнгө зарцуулах, өр, авлага үүсгэсэн аливаа шийдвэр болон таван сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий орлого, зарлагын мөнгөн гүйлгээ, таван сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий худалдан авсан бараа, ажил үйлчилгээний нэр, санхүүжилтийн хэмжээ, нийлүүлэгчийн нэр, хаягийг мэдээлээгүй нийтлэг зөрчил илэрлээ.

6.3 Жил бүр санхүүгийн тайлангийн аудитаар илэрсэн алдаа зөрчлийг холбогдох албан тушаалтанд танилцуулж зөрчлийг давтан гаргахгүй байх аудитын шийдвэрийг хүргүүлж байгаа боловч хуулийн хэрэгжилт бүрэн хангагдахгүй байна.

6.4 Дээрх дурдсан зөрчил дутагдлыг арилгах чиглэлээр аудитын шийдвэрүүдийг гаргаж, баталгаажуулалт хийсэн аудитын тайланд дурдсан болохыг тэмдэглэж байна.

---o0o---

Аудитын дүнд үндэслэн дараах дүгнэлтийг гаргаж байна.

ДҮГНЭЛТ

- Орон нутгийн төсвийн нийт орлогыг 68,326.9 сая төгрөгөөр нийт зарлага ба цэвэр зээлийн дүнг 61,253.2 сая төгрөгийн гүйцэтгэл гарсныг аудитаар баталгаажуулав.
- Төсвийн тухай хуульд заасан нөхцөл байдал үүссэн эсэхэд дүн шинжилгээ хийгээгүй орон нутгийн төсөвт тодотгол хийгдэж байгаа нь Төсвийн төслийг бодитой, хариуцлагатай төлөвлөгөөгүйтэй холбоотой байна.
- Орон нутгийн төсвийн нийт орлогын гүйцэтгэл 86 хувь, зарлага 72.1 хувьтай байгаа нь төсвийн орлогын төлөвлөлтийг сайжруулах шаардлага байгааг илтгэж байна.
- Төсвийн тухай хууль болон бусад эрх зүйн акттай нийцээгүй төсвийн зарлагыг төлөвлөж батлуулан, гүйцэтгэлээр тайлагнасан байна.
- Төсвийн Ерөнхийлөн захирагчийн хөтөлбөр, үр дүнгийн шалгуур үзүүлэлт, хүрэх үр дүнг тодорхой байдлаар төлөвлөөгүйгээс хэмжиж чадахгүй байх нөхцөл байдал үүссэн байна.
- Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилтийн үр дагаврын үнэлгээ хийгдээгүй, байгууллагууд цахим хуудаст мэдээлэл байршуулах ажлын зохион байгуулалт хангалтгүй зэргээс төрийн санхүү, төсвийн үйл ажиллагааны ил тод байдал бүрэн хангагдахгүй байна.

ЗӨВЛӨМЖ:

Аудитаар өгсөн дүн дүгнэлтэд үндэслэн дараах зөвлөмжийг өгч байна.

Сүхбаатар аймгийн Засаг дарга, Санхүү төрийн сангийн хэлтэс:

1. Төсвийн төвлөрүүлэн захирагчийн хэрэгжүүлэх хөтөлбөр, хөтөлбөрийн үр дүнгийн талаарх чанарын болон тоо хэмжээний үзүүлэлтийг төсвийн төлөвлөлттэй уялдуулан төлөвлөх чиглэлээр аргачилсан сургалт, зөвлөмжөөр ханган ажиллах
2. Хөтөлбөр, төсөл арга хэмжээг төсвийн орлогын бааз суурь, хөгжлийн бодлогын баримт бичигтэй уялдуулан төлөвлөж, төсвийн гүйцэтгэлийг бүрэн хангах ажлыг зохион байгуулах
3. Нэр дурдсан ОНӨААТҮГ-уудын үйл ажиллагааны чиглэл, ашигт ажиллагааны түвшнийг шалгуур үзүүлэлтийн дагуу үнэлж дүгнэн, орон нутгийн санхүүгийн дэмжлэгээс бусад орлогын эх үүсвэргүй, өөрийгөө санхүүжүүлэн бие даан үйл ажиллагаа явуулах чадамжгүй газруудад дүн шинжилгээ хийж, хуулийн дагуу арга хэмжээ авах

Аймгийн Татварын хэлтэст:

1. Татварын орлогыг үндэслэлтэй төлөвлөхөд дүн шинжилгээ хийн, төсвийн гүйцэтгэлийг хангахад дэмжлэг үзүүлж ажиллах

Зөвлөмжийн биелэлтийг 2024 оны 09 дүгээр сарын 30-ны дотор багтаан Сүхбаатар аймаг дахь Төрийн аудитын газарт ирүүлэх

САНАЛ:

Хуулийн нийцэлтэй холбоотой дараах саналыг ҮАГ-ын Санхүү-Нийцлийн аудитын газарт уламжилж байна. Үүнд:

- Орон нутгийн авто зам дээр хөдөлгөөний аюулгүй байдлын зөрчил гаргасан, авто замын талаарх хууль тогтоомжийг зөрчсөн этгээдэд ногдуулсан торгуулийн орлогыг авто замын санд төвлөрүүлээгүй нь Авто замын тухай хуулийн 25.2.4 дэх заалттай нийцэхгүй байна. Сүхбаатар аймаг дахь Цагдаагийн газраас авсан мэдээллээр 2023 онд 6,058.04 сая төгрөгийн торгууль ногдуулсан байна. Харин Гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хуулийн 46.1, 46.2 дахь заасны дагуу Зөрчлийн тухай хуулийн 14.7-д заасан “Замын хөдөлгөөний аюулгүй байдлын тухай хууль зөрчлийн торгуулийн орлого”-ийн 40-өөс доошгүй хувийг гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх ажлыг санхүүжүүлэх зохицуулалттай байна. Иймд эдгээр хуулийн хоорондын нийцэл, хэрэгжилтийн талаар холбогдох байгууллагад уламжлуулах
- Сангийн яамны санхүүгийн тайлан, мэдээ гаргадаг цахим сангийн мэдээллийг Шилэн дансны нэгдсэн системд автоматаар байршуулах асуудлыг дээд шатны байгууллагад уламжлах. Тухайлбал ШДТХ-ийн 6.1.1, 6.1.2, 6.1.4, 6.4.1, 6.4.4, 6.4.5-д заасан эдгээр мэдээллийг байршуулснаар нягтлан бодогчийн ажилд эерэг үр дүн болох юм.
- ШДТХ-ийн 6.4.6 (худалдан авах ажиллагаанд хийсэн аудитын тайлан, дүгнэлт болон бусад хяналт шалгалтын дүн)-г худалдан авах ажиллагааны цахим системтэй холбох

